

Яаралтай эмнэлгийн тусламж

Хамгийн ойрын яаралтай тусламжийн төвд очоорой! Шаардлагатай бол 112 руу залгаарай

Яаралтай эмнэлгийн тусламж

Хамгийн ойрын яаралтай тусламжийн төвд очоорой!
Шаардлагатай бол 112 руу залгаарай.

Түргэн тусламж: 112

Эмнэлгийн зөвлөгөө: 1177, ажиллах цаг 24 цагаар.

**Танд тусламж хэрэгтэй эсвэл нэмэлт мэдээлэл хэрэгтэй бол
Улаан загалмайн Эрүүл мэндийн үйлчилгээний зуучлалагчтай
холбогдоно уу:**

Утас: 020-21 10 00 Даваа-Баасан 09:00-12:00 (үнэгүй)

Э-мэйл: rapperslos@redcross.se

Sms: 072-349 98 08 (Зөвхөн sms илгээгээрэй, бидэнтэй ярихыг
хүсвэл 020-21 10 00 дугаар руу залгана уу)

Зочлох хаяг:

Stockholm: Линдхагенсгатан 126, 112 51 Стокгольм, 4 давхар

Göteborg: Руллагергатан 66, 415 05 Готенбург



Co-funded by
the European Union



Healthcare for
undocumented and other
migrants

Swedish Red Cross

Infoservice 0771-19 95 00

E-post: info@redcross.se | www.rodakorset.se



Swedish Red Cross

Бичиг баримтгүй хүн эрүүл мэндийн үйлчилгээ авах эрхтэй гэж хуульд заадаг.

2013 оноос эхлээд хойш бичиг баримтгүй гадаадын харьяат иргэн 2013:407 хуулийн дагуу эрүүл мэндийн үйлчилгээ авах эрхтэй.



Swedish Red Cross

www.rodakorset.se

Эрүүл мэндийн үйлчилгээ авах эрх

Насанд хүрэгч

Та орогнол хүсэгчийн адил эмнэлгийн тусламж авах эрхтэй, өөрөөр хэлбэл хүлээх боломжгүй (хойшлуулах боломжгүй гэж мөн нэрлэдэг) эмнэлгийн тусламж авах эрхтэй. Үүнд шүдний, бие махбодийн, сэтгэцийн тус тус эмчилгээ болон туслах хэрэгсэл багтана. Жирэмсэн болон төрөх эхийн эмчилгээ, жирэмснээс хамгаалах зөвлөгөө, үр хөндөлт, эрүүл мэндийн үзлэг, мөн халдварт өвчний тухай хуулийн дагуу үзүүлэх эмнэлгийн үйлчилгээ үнэ төлбөргүй. Бүсийн эрүүл мэндийн байгууллага нь үүний дээр байнгын оршин суугчидтайгаа ижил түвшинд эмнэлгийн тусламж танд санал болгох боломжтой. Эмнэлгийн тусламж хойшлуулах боломжтой тусламж эсэхийг таны тухайн эрүүл мэндийн байгууллагын ажилтнууд шийднэ.

Хүүхэд

Шведэд түр оршин суугч хүүхдэд байнгын оршин суугч хүүхдийн адил эрүүл мэнд, эмнэлгийн үйлчилгээ болон шүдний эмчилгээ, үйлчилгээг бүрэн хэмжээнд үзүүлнэ. Хүүхдийг Folk tandvården шүдний эмнэлэг болон хүүхдийн эрүүл мэндийн төвд (BVC) хяналтанд бүртгүүлж, хамруулахыг эцэг эх та өөрөө хариуцна.

Хүлээх (хойшлуулах) боломжгүй эмнэлгийн үйлчилгээ гэж юу вэ?

Хойшлуулах боломжгүй эмнэлгийн үйлчилгээ гэдэг нь эрүүл мэндийн

салбарынхны хэрэглэдэг ойлголт бөгөөд таныг одоогийнхоосоо илүү их өвчлүүлэхгүйн тулд шаардлагатай бүх үйлчилгээг үзүүлэхийг хэлнэ. Давтан үзлэг, эмчилгээ мөн үүнд хамаатай. Тиймд та яаралтай эмнэлгийн тусламж дээр нэмж тусламж авах боломжтой гэсэн үг. Хойшлуулах боломжгүй тусламж гэдэг нь та хэрэгтэй үедээ тусламжаа авах ёстой гэсэн үг.

Төлбөр

Эмнэлгийн зардлын дийлэнх хувийг улс төлдөг. Таны өөрөө төлөх ёстой хэсгийг өвчтөний хураамж гэдэг. Хэрэв та тухайн үед хураамжаа төлөх боломжгүй бол нэхэмжлэл гаргуулаад сүүлд нь төлөх боломжтой байх ёстой.

- Эрүүл мэндийн төв эсвэл яаралтай тусламжийн төвд эмчид үзүүлэхэд: 50 крон
- Яаралтай тусламжийн төвд үзүүлэх: Шведэд хаана амьдарч байгаагаас хамааран 50 - 500 крон
- Шүдний эмчийн оношлогоо: 50 крон
- Эмийн сангаас эм гаргуулах: 50 крон
- Туслах хэрэгсэлд: 50 крон
- Өвчтөний унаанд: 25 крон
- Үнэгүй үйлчилгээ:
 - Эрүүл мэндийн үзлэг
 - Халдварт өвчний тухай хуулийн дагуу үзүүлэх үйлчилгээ
 - Орчуулагч
 - Үр хөндөлт
 - Жирэмсэн болон төрөх эхийн эмнэлгийн үйлчилгээ

Нэмэлт мэдээлэл

“Reservnummer”

Таныг эхний удаа эмнэлэгт хандахад reservnummer гэж нэрлэдэг дугаар өгнө. Энэ нь таны эмнэлгийн бүртгэлийг нэг дор цуглуулах болон танд аль болох сайн тусламж үзүүлэхэд чухал ач холбогдолтой дугаар тул та сайн хадгалаарай. Таны хууль ёсны байдал өөрчлөгдсөн буюу та жишээлбэл орогнол хүссэн бол та энэ дугаараа үргэлжлүүлж ашиглах хэрэгтэй. Ийм дугаартай байх нь бичиг баримтгүй байх гэсэн үг биш тул та эрүүл мэндийн байгууллагад хандахдаа заавал ашиглах хэрэгтэй. Хэрэв та reservnummer-аа мартсан бол эмнэлэгтээ хэлэх хэрэгтэй, тэд ихэвчлэн тус дугаарыг компьютерийн системээсээ олж чаддаг.

Бичиг баримт

Эмнэлэгт хандахдаа та id-карт, өмнөх LMA-карт, паспорт эсвэл ямар нэгэн бичиг баримтынхаа хуулбар үзүүлбэл сайн. Id-картгүй ч гэсэн та эмнэлгийн тусламж авах эрхтэй. Бичиг баримтгүй гэдгээ та ямар нэгэн аргаар батлах шаардлагагүй.

Холбоо барих мэдээлэл

Эмнэлгийн байгууллага заримдаа эргээд тантай холбогдохын тулд таны хаяг, утасны дугаарыг асуудаг. Та хаяггүй бол та утасны дугаараа үлдээж болно. Та швед хэл мэдэхгүй бол швед хэлээр ярьдаг таньдаг хүнийхээ утасны дугаарыг үлдээж болно. Та c/o хаягтай буюу өөр хүний хаяг ашигладаг бол хаяг дээрх хаалган дээрх нэрийг бичих

нь чухал. Та ойр ойрхон нүүдэг бол эмнэлэгтэйгээ холбоо таслахгүйн тулд утасны дугаараа үлдээх хэрэгтэй.

Нууцлал

Эмнэлгийн ажилтнууд бүгд нууцлалыг чанд сахих ёстой бөгөөд тэд Цагаачлалын алба, цагдаа зэрэг эрх бүхий байгууллагад таны тухай мэдэгдэж болохгүй.

Эмийн сан ба жор

Эмийг цахим жороор гаргуулахад тодорхой эмийн сангаар гаргуулах ёстой ба та id-картаа үзүүлэх шаардлагатай. Хэрэв танд id-карт байхгүй бол эмийг жороо цаасан жорын хуудас дээр бичүүлэх хэрэгтэй. Шведийн ихэнх хэсэгт нэг өдөр бичүүлсэн эмийн жорд 50-аас илүү крон төлөх шаардлагагүй тул ингэж бичиж өгөөч гэж эмчээс хүсч болно. Эмч жорынхоо тунг заадаг мөр дээр “utan tillstånd, betalas av region...” гэж бичсэн бол та эмийг бүтэн үнээр төлөх шаардлагагүй болно. Хэрэв та орогнол хүсэгч байх үедээ эмийн жороо бичүүлж байсан бол LMA-картын хугацаагаа дуусах үед эмчээрээ шинэ жор бичүүлэх хэрэгтэй.

Таны өвчний түүх

Та өвчний түүхээ цаасан дээр хэвлүүлж гаргуулах эрхтэй бөгөөд эмнэлэгт хандаж үүнийг хүсч болно.

Орчуулагч

Та орчуулагч авах эрхтэй.